

Хууль зүйн ухааны доктор (Ph.D) Х.Сэлэнгэ

МУИС, Хууль Зүйн Сургууль,

Эрх зүй, төрийн онол-түүхийн тэнхимийн багш

ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИЙН ОРЧИН ҮЕИЙН ХАНДЛАГА

Түлхүүр үг: эрх зүйн философи, эрх зүйн онол, эрх зүйн догматик, эрх зүйн позитивист танин мэдэхүйн онол.

Хүн төрөлхтөн нийгэмшлийн үеэсээ эхлэн өөр хоорондын харилцааг зохицуулах хамгийн зохистой арга хэлбэрийг эрж хайх болсоноор эрх зүйн тухай санаа үүсч, "зөв шударга эрх зүй" - н тухай эрэгцүүлэн, эрх зүйн үнэнд хүрэхийг эрмэлзсээр ирсэн билээ. Эрх зүйн тухай хүний оюун ухааны энэхүү эрхэм зорилгыг шийдвэрлэгч нь эрх зүйн философи юм.

Эрх зүйн философи нь эрх зүйг танин мэдэх оюуны дээд хэлбэр¹⁶ болохынхоо хувьд эрх зүйн мөн чанар, агуулга, түүний илрэл, тэдгээрийн харилцан хамаарал, нөлөөлөх хүчин зүйлүүдийг философийн категорийн тусламжтайгаар судлаж, гносеологи, онтолог, аксеологийн асуудлыг хөндөн, хууль зүйн шинжлэх ухааны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд онол – арга зүйн хувьд үнэтэй хувь нэмрийг оруулж байна.

Эрх зүйн философийн үндэс м.э.ө Ү зуунаас тавигдаж, ХҮШ-ХІХ зуунаас философи – эрх зүйн мэдлэгийн томоохон салбар болж, өнөөг хүртэл хөгжиж байгаа хэдий ч шийдвэрлэгдээгүй тулгамдсан асуудлууд нилээд байгаа юм. Шийдвэрлэгдээгүй байгаа асуудлуудаас бидний анхаарлыг татаж байгаа асуудал бол "эрх зүйн философи нь философийн нэг хэсэг үү? Эсвэл хууль зүйн шинжлэх ухааны нэг хэсэг үү?" гэсэн асуудал болно. Өнгөрсөн түүхийг эргэн харвал, Германы нэрт сэтгэгч Гегель нь "Эрх зүйн философи" номондоо: "Эрх зүйн тухай шинжлэх ухаан нь философийн нэг хэсэг мөн. Иймд энэхүү шинжлэх ухаан нь эрх зүйн өөрийн дотоод хөгжлийг шинжлэх, эсвэл эрх зүйн тухай санааг төсөөлөх эрх зүйн санааны ойлголтоос л хөгжих ёстой"¹⁷ гэжээ. Германы нэрт сэтгэгч Гегелийн энэхүү үзлийг нилээд эрдэмтэн судлаачид хүлээн зөвшөөрч дэмждэг бөгөөд эдгээрийн олонхи нь философичид байгаа болно. Мөн манай ихэнхи эрдэмтэд ч энхүү үзлийг

¹⁶ Нерсесянц, В.С. Философия права. М.1997. с 5.

хүлээн зөвшөөрч, "эрх зүйн философи нь нийгмийн салбар шинжлэх ухааны философийн /шашны философи, түүхийн философи г.м./ нэгэн адил ерөнхий философийн нэг хэсэг" хэмээн үздэг. Харин ХХ зуунаас эрх зүйн философийг хөгжүүлж, онолын сэтгэлгээг боловсронгуй болгож буй эрдэмтэдийн нилээд нь хууль зүйн шинжлэх ухааны эрдэмтэн судлаачид байгаа бөгөөд тэд эрх зүйн философийг хууль зүйн шинжлэх ухааны нэг хэсэг хэмээн үзэх болжээ. Тухайлбал, Германы эрдэмтэн Г.Хенкель эрх зүйн философийг хууль зүйн шинжлэх ухааны салбар¹⁸ хэмээн үзсэн. Ийнхүү сүүлийн үед эрх зүйн философийг хууль зүйн шинжлэх ухааны салбар хэмээн үзэх болсоныг Оросын эрдэмтэн В.С.Нерсесянц¹⁹ : ХХ зуунаас философи – эрхийн судлалын гол асуудал нь аажмаар хууль зүйн шинжлэх ухааны хүрээ рүү шилжиж байна²⁰ хэмээн дүгнэн бичжээ.

Эрх зүйн философи нь философийн нэг хэсэг үү? Эсвэл хууль зүйн шинжлэх ухааны нэг хэсэг үү? гэсэн асуудлаар эрдэмтэн судлаачид санал нэгдмэл бус байдаг учир Францын "Эрх зүйн философийн архив" сэтгүүлээс маргаантай асуудлыг шийдвэрлэх үүднээс европын 25 томоохон эрдэмтэдийн дунд судалгаа явуулсан байна. Судалгааны үр дүнд эрх зүйн философийг хууль зүйн шинжлэх ухааны нэг хэсэг болохыг олонхи эрдэмтэд хүлээн зөвшөөрчээ. Энэ нь хууль зүйн шинжлэх ухаанд эрх зүйн философи нь эрх зүйн догматик, эрх зүйн онол, эрх зүйн социологийн нэгэн адил бие даасан нэг салбар болон хөгжиж байгаатай холбоотой хэмээн үзэж болох юм. Харин философийн хүрээнд эрх зүйн философи нь одооноос л дөнгөж ийм статустай болж байгаа билээ. Тухайлбал, ихэнхи гадаад, дотоодын их дээд сургуулиудад эрх зүйн философийн лекц нь хуулийн ангийн оюутнуудад л уншигддаг.

Нөгөө талаар хэрвээ эрх зүйн философийг философийн нэг хэсэг хэмээн үзвэл юуны өмнө "философи" гэж юу вэ? гэсэн асуултанд үнэн зөв, тодорхой хариулт өгөх шаардлагатай. Гэвч энэхүү асуултанд хуульчид байтугай, философичид өөрсдөө нэгдмэл харилт өгч чадахгүй байгаа билээ. Мөн эрх зүйн философийг ерөнхий философийн нэг хэсэг хэмээн үзэж байгаа

¹⁷ Гегель. Философия права. М. 1990. С 60.

¹⁸ Нерсесянц. В.С. Философия права. М.1997. с 556.

¹⁹ Оросын эрдэмтэн В.С.Нерсесянц нь эрх зүйн философийг философийн нэг хэсэг хэмээн үздэг юм.

²⁰ Нерсесянц. В.С. Философия права. М.1997. с 554.

бол нийгмийн салбар философиудтай /шашны философи, түүхийн философи г.м./ зэрэгцүүлэн хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Өнөөг хүртэл эрх зүйн философийн хүрээнд төдийлөн бүрэн шийдвэрлэгдээгүй бас нэгэн асуудал бол эрх зүйн философи, эрх зүйн онол нь хууль зүйн шинжлэх ухааны нэг салбар уу? эсвэл тус тусдаа биеэ даасан салбар уу? гэсэн асуудал юм.

Оросын эрдэмтэдийн хувьд эрх зүйн философи, эрх зүйн онол, эрх зүйн социологийн талаар тэдний үзэл санаа эрс зөрчилтэй байдаг юм. Тухайлбал, Оросын эрдэмтэн Г.Ф.Шершеневич эрх зүйн философийн агуулга нь дараахи гурван хэсгээс бүрддэг хэмээн үзжээ. Үүнд:

1. Эрх зүйн ерөнхий онол
2. Эрх зүйн философийн түүх
3. Эрх зүйн улс төрийн бодлого²¹

Эндээс үзвэл Г.Ф.Шершеневич нь эрх зүйн онолыг эрх зүйн философийн нэг хэсэг гэж үзжээ. Гэтэл Оросын эрдэмтэн А.Д.Керимов үзэхдээ: Эрх зүйн ерөнхий онол нь өөртөө эрх зүйн социологи, эрх зүйн философи гэсэн хоёр үндсэн хэсгийг агуулдаг²² хэмээн эрх зүйн онолд эрх зүйн философи, эрх зүйн социологийг багтааж байна.

Харин Оросын эрх зүйн онолын гол төлөөлөгч С.С.Алексеев "Эрх зүйн философи" номондоо: хууль зүйн шинжлэх ухааны салбарт эрх зүйн философийн зэрэгцээгээр эрх зүйн ерөнхий онол нь бие даасан байр суурийг эзэлдэг²³ гэж үзсэнээрээ эрх зүйн онол, эрх зүйн философийг тус тусдаа бие даасан салбар хэмээн үзжээ.

Европын хуульч-эрдэмтэдийн хүрээнд ч эрх зүйн философи, эрх зүйн онолын талаар нэгдмэл ойлголт байхгүй байна. Иймд Францын "Эрх зүйн философийн архив" сэтгүүлээс дээрхи асуудлыг шийдвэрлэх үүднээс судалгаа явуулсан юм. Судалгааны үр дүнг үзвэл, эрх зүйн философи, эрх зүйн онол нь тус тусдаа бие даасан салбар болохыг олонхи эрдэмтэд хүлээн зөвшөөрсөн байна. Учир нь:

- Эрх зүйн философи, эрх зүйн онол нь гарал үүслээрээ ялгаатай юм. Эрх зүйн философи нь эртний Грекээс, эрх зүйн онол нь эртний Ромоос үүсэлтэй.

7. Шершеневич. Г.Ф. Общая теория права. М. 1995. с. 26.

8. Керимов. Д.А. Основы философии права. М. 1992. с. 5.

9. Алексеев. С.С. Философия права. М. 1998. с. 22.

- Эрх зүйн философи, эрх зүйн онол нь судлах зүйлээрээ ялгаатай.

Эрх зүйн философи нь эрх зүйг танин мэдэхүйн сэтгэлгээний түвшинд философийн категориудын тусламжтайгаар судалж, эрх зүйн бодит агуулга, мөн чанарыг танин мэдэхэд чиглэглэгдсэн шударга ёсны онол байдаг бол эрх зүйн онол нь эрх зүйн хэлбэрийг голлон норматив аргад үндэслэн хэм хэмжээний хүрээнд судалдаг. Гэхдээ эрх зүйн философи, эрх зүйн онол нь ~~хэрэгжид~~ нилээд төстэй, ялгаа нь төдийлэн тодорхой бус байдаг нь энэхүү онолын хоёр салбарыг ялгаж зааглахад хүндрэл учруулдаг юм. Иймд Германы эрдэмтэн А.Кауфман: "Эрх зүйн философи нь илүү агуулгын шинж чанартай, эрх зүйн онол нь илүү хэлбэрийн шинж чанартай гэдгийг яг тэр утгаар нь ойлгох нь бас учир дутагдалтай боловч, хэлбэргүй агуулга болон агуулгагүй хэлбэр гэж байдаггүй учир хооронд нь яг таг ялгаж салгахад түвэгтэй юм. Эрх зүйн философитой адил төстэй тал нь гэвэл эрх зүйн онол нь зөвхөн хүчин төгөлдөр буй эрх зүйгээр хязгаарлагддаггүй, харин ихэнхи тохиолдолд шууд бус боловч "үнэн зөв эрх зүй"-д чиглэгддэг... Эрх зүйн онол нь эрх зүйн философоос эцсийн дүнд зөвхөн шалтгаан (мотив)-аараа ялгагддаг юм...Тэгсэн хэдий боловч энэ аспект нь ч эрх зүйн философи, эрх зүйн онолыг хооронд нь ялгаж салгах тов тодорхой шалгуур болж чадахгүй юм. Тийм учраас эрх зүйн онолд чухам юу хамаардагийг тоочихоос өөр боломжгүй юм. Үүнд: тухайлбал, хэм хэмжээний тухай онол, цэвэр эрх зүйн онол, шийдвэр гаргах тухай онол, эрх зүйн шинжлэх ухааны онол, тогтолцооны тухай онол, эрх зүйн задлан шинжлэх ухаан, марксист эрх зүйн онол, эрх зүйн хэллэгийн тухай онол, үндэслэлийн тухай онол, хууль тогтоох тухай онол, эрх зүйн семантик онол, эрх зүйн хэллэгийн урлаг г.м. орно²⁴" гэжээ.

Монголын хуульчдын хүрээнд эрх зүйн философи, эрх зүйн онол, эрх зүйн догматикийг нарийн ялгаж зааглаж чадахгүй байгаа бөгөөд үүний нэгэн жишээ нь эрх зүйн онолын хичээлээр голлон эрх зүйн догматикийг заахын зэрэгцээ жам ёсны эрхийн онол, позитив танин мэдэхүйн асуудал г. м. эрх зүйн философийн асуудлуудыг заах тохиолдол нилээд байна. Эрх зүйг судлах судалгааны түвшин улам нарийсаж, онолын сэтгэлгээ өргөн хүрээтэй хөгжиж байгаа өнөөгийн нөхцөлд эрх зүйг судалдаг эрх зүйн философи, эрх зүйн онол, эрх зүйн догматик, эрх зүйн социологийг зөв ялгаж зааглан зааж,

²⁴ Kaufmann A., 1997. Rechtsphilosophie. pp. 12-13.

оюутнуудад эрх зүйн онолын мэдлэгийг эзэмшүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Орчин үед эрх зүйн философийн хувьд эрх зүйн мөн чанар, бодит агуулга, түүний илрэл, тэдгээрийн харилцан хамаарлыг судлах явдал нь онол - арга зүйн хувьд улам гүнзгийрэн хөгжиж, эрх зүйн үзэгдлүүдийг улам нарийвчлан судалж, эрх зүйн салбар шинжлэх ухааны философи /эрүүгийн эрх зүйн философи, иргэний эрх зүйн философи г.м./ хөгжих үндэс тавигдаж эхэллээ.

Эрх зүйн философийн онолын сэтгэлгээний хандлага нь эрх зүйн санааны үүсэл, үндэс, зорилгыг харгалзан жам ёсны эрхийн / юснатурализм / ба позитив эрхийн чиг хандлага / хууль зүйн болон социологийн позитивизм / гэсэн хоёр том үндсэн уламжлалт урсгалд хуваагдсан хэвээр байгаа нь Ром - Германы болон Англо-Саксоны эрх зүйн сэтгэлгээнээс ажиглагдаж байгаагийн зэрэгцээ олонхи эрдэмтэд эрх зүйн сэтгэлгээний чиг хандлагыг гурван чиглэлд хуваан:

- “Шударга ёсны онол”-д тулгуурласан “Жам ёсны онол”-ын /юснатурализм/ буюу идеалист чиг хандлага,
- Хууль зүйн аюулгүй байдлыг хангах үүднээс эрх зүйн гадаад хэлбэр талыг голлодог “Позитив” буюу “формаль” чиг хандлага,
- Эрх зүйг нийгмийн үзэгдэл болохын хувьд социологийн аспектын үүднээс авч үздэг “Реалист” чиг хандлага хэмээн авч үзэх явдал зонхилж байна.

Эхний чиг хандлага нь “эрх зүй ямар байх ёстой вэ?” гэдгийг судалдаг хийсвэр, онолын шинжтэй бол сүүлийн хоёр чиг хандлага нь эрх зүйд харьцангуй бодитой хандаж “эрх зүй ямар байна вэ?” гэдгийг судалдагаараа онцлогтой.

Эрх зүйн сэтгэлгээний үндсэн чиг хандлагуудад анализ хийхдээ эрх зүйн сэтгэлгээний чиг хандлагуудад нийтлэг байгаа эрх зүйн анхдагч эх сурвалж, эрх зүйн илрэн гарах хэлбэр, эрх зүй хуулийн харилцан хамаарлын асуудлыг гол шалгуур болгон нягтлан үзвэл; жам ёсны эрхийн үндсэн хэлбэр нь хуульчлагдан баталгаажсан эсэхээс үл хамаардаг хүний эрх, эрх чөлөө байдаг бол түүний үүсмэл хэлбэр нь жам ёсны эрхийн хамгаалалт болох төрөөс тогтоосон норматив актууд байгаа болно. Харин хууль зүйн позитивизмд эрх зүйн үндсэн хэлбэр нь эрх зүйн норматив актуудаар /хууль

ба хуульчилсан актууд/ илрэх бөгөөд эрх зүйн үүсмэл шинжтэй эх сурвалжид нь норматив гэрээ, норматив шинжийг агуулсан акт /шүүхийн тайлбар/ г.м. эх сурвалжууд багтдаг. Эрх зүйн реалист танин мэдэхүйн хүрээнд эрх зүйн илрэх хэлбэр нь амьд эрх /нийгмийн социаль бүлэглэлийн эрх, шүүхийн эмпирик шийдвэр/, мөн позитив эрх юм. Эрх зүйг социологийн аспектын үүднээс авч үзэхэд эрх зүйн хэлбэрийн шатлалын хувьд нийгмийн хөгжлийн объектив зүй тогтол нь позитив эрхийн өмнө байдаг онцлогтой болно.

Эрх зүй, хуулийн харилцан хамаарлын хувьд хууль зүйн позитивизм энэхүү хоёр ойлголтыг адилтгаж үздэг бол жам ёсны эрхийн онол ялгаж зааглахаас гадна харилцан нөхцөлдүүлэн авч үздэг, харин социологийн аспектын үүднээс авч үздэг чиг хандлага нь позитив эрхийн хэм хэмжээ, эрх зүйн харилцааны харилцан хамаарлын үүднээс авч үздэг юм.

Дээрхи эрх зүйн сэтгэлгээний хандлагыг дүгнэвэл, энэхүү үндсэн гурван чиг хандлагууд нь:

- Эрх зүйн норматив шинжийг үгүйсгэхгүй байна.
- Эрх зүй нь нийгмийн үзэгдэл болохын хувьд олон талт, нарийн асуудал боловч төрийн институтгүйгээр орших боломжгүй болохыг хүлээн зөвшөөрч байна.
- Хууль зүйн позитивизм, социологийн позитивизм нь хоорондоо холбоотой бөгөөд эрх зүйн нэгдмэл инструменталь - функциональ системийн элемент хэмээн үзэж болохоор байна.

Эрх зүйн танин мэдэхүйн дээрхи үндсэн чиг хандлагуудад анализ хийхдээ өмнө дурьдсан шалгууруудыг харгалзан үзэхийн зэрэгцээ онтолог, аксеологийн аспектыг орхигдуулж болохгүй.

Жам ёсны эрхийн хандлага нь танин мэдэхүйн онолын үүднээс эрх зүйн мөн чанар, бодит агуулгыг тодорхойлж, эрх зүйн үнэнд хүрэхийг эрмэлздэг бөгөөд онтологийн үүднээс эрх зүй оршин буйг нотолж, эрх зүйн объектив шинж, үүрэг зорилгыг илрүүлж, хууль нь эрх зүйн үзэгдэл, эрх зүйн илрэх гадаад хэлбэр болохыг тодорхойлдог. Харин аксиологийн үүднээс эрх зүйн объектив мөн чанар, үнэт зүйлсийг илрүүлж, түүний зорилго, ач холбогдлыг тодорхойлж өгдөг.

Эрх зүйн позитив танин мэдэхүйн онолын ашиг сонирхол нь позитив эрхэд төвлөрч байдаг учир позитив эрхийн хүрээнээс гарсан эрх зүйн мөн чанар, эрх зүйн санаа, эрх зүйн үнэт зүйлс гэх мэт эрх зүйн санаануудыг үгүйсгэдэг. Энэ нь үндсэндээ эрх зүйн онолыг үгүйсгэж, гагцхүү хууль зүй судлал, хууль зүйн сургаал байхыг номлож, хууль зүй судлалын судлагдахуун нь зөвхөн позитив эрх байна хэмээн үздэг юм. Позитивист танин мэдэхүйн хувьд үйлчилж буй эрх зүйг /хуулийг/ танин мэдэх гэдэг нь хуулинд тусгагдаагүй шинэ мэдлэгийг олж авах, хуулийн мөн чанарыг танин мэдэх асуудал биш юм. Учир нь эрх зүйн тухай бүх мэдлэг нь позитив эрхэд, түүний текстэд байгаа учраас гагцхүү хуулийн текстийг зөв тайлбарлах явдал хэмээн үздэг байна. Үүнтэй уялдан позитивистүүд лингвистик философитой холбогддог юм.

Харин позитивист бус чиг хандлага нь лингвистик философийн болон герменевтик философийн арга зүйг хүлээн зөвшөөрдөг боловч эрх зүйн догмыг судлахад бус, харин эрх зүй ба хуулийн тухай үнэн зөв мэдлэг олж авах, эрх зүйг бүх талаас нь судлахад танин мэдэхүйн бүх аргуудыг хэрэглэх үүднээс л хүлээн зөвшөөрдөгөөрөө легизмээс ялгаатай байна.

Үнэт зүйлсийн хүрээнд позитивизм нь эрх зүй, хууль хоёрыг адилтгадаг учир эрх зүйн үнэт зүйлсийг үгүйсгэж, хуулийн үнэт зүйлсийг л хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ бодит байдалд хуулийн үнэт зүйлс нь үнэт зүйлсийн агуулгаасаа гажих тохиолдол байдаг.

Эрх зүйг социологийн аспектын үүднээс авч үздэг реалист чиг хандлага нь эрх зүйн плюрализмын үүднээс төрийн хууль тогтоох монополь эрхийг үгүйсгэж, амьдралаас урган гарсан нийгмийн социаль бүлэглэлийн эрхийг "амьд эрх зүй" хэмээн үзэж, хуульчдын үйл ажиллагаа, туршлагыг үнэт зүйл хэмээн үздэг онцлогтой болно.

Эрх зүй нь нийгмийн үзэгдэл болохын хувьд олон талтай, нилээд өргөн хүрээтэй, нарийн асуудал боловч эцсийн дүнд хүнээс ангид авч үзэх боломжгүй үзэгдэл юм. Иймд өмнөх үед эрх зүйн ахуйг "байгаа зүйлтэй", гадаад юмс үзэгдэлтэй адилтган авч үзэж байсныг өнөө үед шүүмжлэн эрх зүйн ахуйг дотроос нь хайх шаардлагатай хэмээн үзэх боллоо. Энэ үндсэнд эрх зүйг бодгаль хүнээс үүсмэл хэмээн үзэж, хүний мөн чанарыг танин мэдэхгүйгээр эрх зүйн мөн чанарыг танин мэдэх боломжгүй хэмээн үзэх болжээ. Хэрвээ эрх зүйн мөн чанарыг бодгаль хүнээс гадуур эрвэл эрх зүйн

үнэн, бодит уг сурвалжийг хэзээ ч олж чадахгүй бөгөөд нийгэм, төр гэдэг бол эрх зүйн уг сурвалж бус, харин бүтээгдсэн эрх зүйн амьдрах орчин хэмээн үзэх болжээ.

Эрх зүйд хандах арга зүй нь монизмаас плюрализм руу шилжих болсон өнөө үед эрх зүйн сэтгэлгээ нь эрх зүйн плюрализмд тулгуурлан эрх зүйн сэтгэлгээний онол урсгалуудыг эсрэг тэсрэг байрь сууринд тавихыг төдийлэн эрмэлзэхгүй боллоо. Энэ нь эрх зүйн онолын сэтгэлгээ нь интеграцлагдаж, харилцан бие биенээ хүлээн зөвшөөрөх хандлага бий болсонтой холбоотой юм. Тухайлбал, уламжлалт эрх зүйн сэтгэлгээнд жам ёсны эрх ба позитив эрхийг хооронд нь сөргөлдүүлэн авч үздэг байсан бол сүүлийн үед жам ёсны эрхийн онол, позитивизм нь харилцан бие биенээ хүлээн зөвшөөрөх хандлагатай болсон нь ажиглагдаж байна. "Позитивизм орчин үед" гэсэн номонд "позитивизмын нэг ч төлөөлөгч эрх зүйн агуулгын ёс зүйн шинжийг үгүйсгэхгүй байна" хэмээн бичсэн бол неопозитивизмын төлөөлөгч Г. Харт нь ёс суртахууны нөлөөгөөр эрх зүй хөгжиж байдаг ба эрх зүй нь ёс суртахууны хөгжилд нөлөөлдөг болохыг үгүйсгэхгүй байна²⁵ гэжээ. Ийнхүү позитивистүүд орчин үед эрх зүйн агуулгын ёс суртахууны шинжийг үгүйсгэхгүй байгаагийн зэрэгцээ хуулийг /позитив эрх/ төгс сайн болгохын тулд позитив бус чиг хандлага байгаа хэмээн жам ёсны эрхийн онолыг хүлээн зөвшөөрөх болжээ. Энэ тухай Роджер Шайнер "хууль зүйн позитивизм, жам ёсны эрхийн онол нь хоорондоо ойртон хөгжиж байна" хэмээн үзсэн бол Италийн эрдэмтэн Лэтиция Жианформаджио: "Жам ёсны эрх ба позитив эрх нь нэг нь нөгөөгүйгээр орших боломжгүй юм. Жам ёсны эрх нь шударга зөв боловч позитив эрхгүйгээр хэрэгжих боломжгүй. Энэхүү хоёр чиг хандлага нь харилцан бие биенээ нөхцөлдүүлж байна²⁶ хэмээн жам ёсны эрх ба позитив эрхийн хосолмол шинжийн тухай өгүүлж байна.

Нөгөө талаар императив болон бусад хэм хэмжээний зэрэгцээгээр зөвлөмж, стандарт, хэв маяг, загварын шинжтэй хэм хэмжээнүүд нилээд түгээмэл байхын зэрэгцээ эрх зүйн зарчмуудын үнэ цэнэ, ач холбогдол өсөн нэмэгдэж байна. Үүнээс улбаалан эрх зүй нь нийгмийн бусад хэм хэмжээтэй ойртож байгаа нь эрх зүйн эх сурвалжын асуудалд /шүүхийн практикийг хамааруулан/ шинэ хандлагаар хандахыг шаардах боллоо.

²⁵ үз; Hart H.L.A. Law, Liberty and Morality. L., 1963.P.1.

²⁶ Gianformaggio L. Droit naturel // Dictionnaire encyclopedique de theorie et de sociologie du droit. Bruxelles, 1988, p 116

Мөн орчин үед эрх зүйн танин мэдэхүй нь нийгэм, иргэдээс эрх зүйд хандах хандлага, түүний үнэлэмжийн асуудлыг агуулах болсон бөгөөд өнөөгийн эрх зүйн интеграцын явцад эрх зүйн сэтгэлгээний зөрчил аажмаар бүдэгрэн, харин эрх зүйн үйлчлэлийн нэгдсэн механизмыг гүнзгийрүүлэн судлах явдал чухал болж байна.

Гэвч эрх зүйн плюрализм хөгжиж буй өнөө үед зарим хуульч эрдэмтэдийн дунд эрх зүйн нэгдмэл тодорхойлолтыг эрж хайх явдал байсаар байгаа боловч эрх зүйн нэгдмэл үзэл баримтлалыг бий болгох явдал нь тийм ч үр дүнтэй бус байгаа юм. Учир нь, хэрвээ эрх зүйн нэгдмэл тодорхойлолт байна гэвэл, энэ нь түгээмэл /универсаль/ шинжийг агуулсан байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, уг тодорхойлолт нь аль ч цаг үе, хаана ч, ямар ч эрх зүйн тогтолцоонд тохирч байх ёстой. Гэтэл Ром–Германы болон Англо–Саксоны эрх зүйн бүл нь шүүх, захиргааны актыг янз бүрээр авч үзсээр ирсэн билээ. Нөгөө талаар, онолын болон практик арга зүйг нэгтгэж болох уу? гэсэн асуулт зүй ёсоор тавигдана. Мэдээж онолын болон практик арга зүйн хооронд ялгаа зааг бий. Эцсийн үр дүнд эрх зүйд хандах чиг хандлагуудын ялгаа нь “байгаа ” болон “байх ёстой”-н ялгаа буюу “эрх зүй ямар байна вэ?” /бодит/ болон “эрх зүй ямар байх ёстой вэ?” /хийсвэр/ хоёрын хоорондын ялгаа юм. Үүнийг арилгах үүднээс Ханс Кельзений “Цэвэр эрх зүйн онол” үүссэн билээ.

Эрх зүйн онолын сэтгэлгээний “Формаль” болон “Реалист” чиг хандлага нь уламжлалт онолын сэтгэлгээгээ нилээн хадгалж байгаа нь ажиглагдаж байна. Гэхдээ эрх зүйн норматив танин мэдэхүй нь уламжлалт “нормативизм”-аас үндсээрээ ялгаатай бөгөөд эрх зүйг хэм хэмжээний нийлбэр цогц хэмээн үзэх бус, харин нийгмийн бодит харилцаа, “байгаа зүйл”-ээс салангид орших “хийсвэр - байх ёстой”, “төгс агуулгатай” хэм хэмжээ хэмээн ойлгон тайлбарлах болсон байна. Логикийн позитивизмын хөгжлийн үр дүнд Ханс Кельзений “Цэвэр эрх зүйн онол” олон улс орны төр, эрх зүйн онолын сэтгэлгээнд түгээмэл дэлгэрэн хөгжиж байгаа хэдий ч, түүний үзэл онолын эсрэг “Интеграцын” болон “Коммуникацын” онол гарч ирлээ.

Мөн өнгөрсөн зуунд эрх зүйн танин мэдэхүйн өмнөх арга зүйн зарчмуудад / позитив ба позитив бус / үндэслэгдсэн, үүсмэл хэмээн үзэж болох, эрх зүйн мөн чанарыг тодорхойлоход чиглэгдсэн интегратив арга зүй

шинээр бий болсон. Энэхүү интегратив арга зүйд эрх зүйн ухамсар, эрх зүйн харилцаа, эрх зүйн хэм хэмжээ нь нийлж, нэгдсэн байдагаараа онцлогтой. Өөрөөр хэлбэл, эрх зүйн харилцаа, эрх зүйн хэм хэмжээ ямар байх ёстой вэ? гэдгийг судалдагаараа онцлогтой байна.

Эрх зүйн сэтгэлгээний өмнөх үед байгаль нийгмийг сөргүүлэн тавьдаг байсан бол орчин үед "экосоциосистем"-ын онолын чиг хандлага нийгмийн бүхий л салбарт хөгжих болсоноор байгаль нийгмийг бүхэлд нь авч үзэх "системийн" болон "хувьсалын" онол тэргүүлэх боллоо.

"Хувьсалын онол"-ын хөгжлийн явцад эрх зүйн онолын сэтгэлгээний чиг хандлага нь формаль логикоос хувьсах логик руу гэсэн чиг хандлагатай болж байна. Үүнээс шалтгаалан эрх зүйн онолын үзэгдлүүдэд хандах хандлага өөрчлөгдөж байгаа юм. Тухайлбал, объект субъектын ойлголтонд өөрчлөлт орж, үл хөдлөх өмчид газраас гадна хувьцааг ч хамааруулан ойлгох боллоо.²⁷

"Системийн онол" эрх зүйн тогтолцооны хүрээнд төдийгүй салбар, институтын түвшинд хэрэглэгдэж байна. Тухайлбал, шүүгчийн зорилго нь гэм бурууг тогтоохоос гадна зөв шийдвэр гаргах явдал хэмээн үзэх болсон учир шүүгч нь аливаа хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хууль зүйн асуудлыг төдийгүй антропологи, психологи, эдийн засаг гэх мэт нийгмийн бүхий л хүчин зүйлүүдийг харгалзан үзэж эцсийн шийдвэрийг гаргах ёстой болж байна.

Харин идеалист хандлага нь улам гүнгийрэн хөгжиж байна. Үүний үндсэнд орчин үед эрх зүйн онолын сэтгэлгээнд үзэл санааг зөвшөөрөхүй нь үнэний болон шударга ёсны гол шалгуур байна хэмээн үздэг "Шударга ёсны процедурын онолууд" гол байр суурийг эзлэх боллоо.

"Шударга ёсны процедурын онол"²⁸ нь И.Кантын объектив, субъективын алинаар нь ч бус, харин процесст төвлөрөн сэтгэх танин мэдэхүйн арга зүйд тулгуурлаж байгаагаараа онцлог юм. Эрх зүйн зорилго нь: шударга үнэнийг баримталж, хуулийн хүрээнд үнэн зөв шийдвэр гаргахад оршдог билээ. Гэхдээ онол болоод практикийн хувьд үнэн эсвэл худал, зөв эсвэл буруу эсэх асуудлыг тогтсон хүрээнд ялган зааглан авч үзэх шаардлагатай. Иймд эмпирик хэллэгийн хүрээнд үнэн, эсвэл худал байдаг учир норматив өгүүлбэрийн үнэн, зөвд анхаарлыг хандуулдаг юм.

Шүүх процесс буюу практикт зөв эсвэл буруу болох талаар хуулийн хэм хэмжээнд тогтоосон томъёолол бий. Жам ёсны /натур/ эрхийн сургаалаар

²⁷ Х.Тэмүүжин. Эрх зүй, төрийн онол-түүхийн онолын семинарт тавьсан илтгэлээс.

зөвхөн “зөв” эрхийн хэм хэмжээний талаар төдийгүй бодит байдлын хэллэгийн талаар тайлбарладаг. Номинализм ба эмпиризмийн хувьд норматив хэллэг бол хэзээ ч үнэн бус гэж үздэг. Дээрхи хоёр үзэл баримтлалыг хоёуланг нь “Шударга ёсны процедурын онол” үгүйсгэдэг онцлогтой. Ричард М. Хар-н /Richard M. Hare/ үзэж байгаагаар норматив хэллэгийг универсальчилсан нь , тухайлбал, “а бол сайн” гэдэг нь “а бол улаан” гэсэн дескриптив илэрхийлэлтэй утга нэгэн юм. Нийцэн зохицох байдал (Ubereinstimmung) болон хүмүүсийн ойлгон ухамсарлах байдал (интерсубъективитет) нь нормативийн хүрээнд зарим хэсгээрээ дескриптивийн хүрээний адил бусад факторуудаас хамааралтай байдаг. Иймээс норматив шийдвэрийг гаргахад логикийн модалитетийг (аливаа нэг хэллэг тодорхой эсэхийг илэрхийлсэн хэмжээ гэх мэт) тухайлбал, “боломжгүй”, “шаардлагатай”, “зайлшгүй” –г хэрэглэхгүй, харин “тодорхой”, “хүлээн зөвшөөрөгдсөн”, “үндэслэлтэй” гэсэн ойлголтыг хэрэглэдэг билээ. Нөгөө талаас норматив хэллэг нь эмпирик хэллэгтэй харьцуулахад тодорхой болон ойлгомжтой байж чадахгүй байх явдал нилээд тохиолддог. Гэвч норматив хэллэгийн хувьд :

- нотолгооны шаардлагагүй тодорхой байх ба эмпирик судалгаа, мөн логик бүхий баримтаар хамааралгүй гэдгийг нотлох,
- туршлага ба ажиглалт,
- ойлгомжтой болгох ба рациональ аргумент,
- интерсубъективитет ба универсальчлагдсан байдлын шалгуурууд нь үнэн (зөв) мэдлэгийн талаар авч үзэх ба ингэхдээ зөвхөн ганцхан үнэн зөв шийдвэр гэж бараг байхгүй, харин ихэнхидээ “орлуулж болох” (олон янзын), “үнэн зөв” хариулт байж болох талаар заасан байна. / Энэ нь зөвхөн хуульчид болон нийгмийн шинжлэх ухааны эрдэмтдийн хүрээнд дэх онолын асуудал (проблем) биш бөгөөд мөн байгалийн шинжлэх ухааны хувьд ч нилээд өргөн хүрээг хамарч буй асуудал болно /

Дээрхээс дүгнэн үзвэл: норматив шийдвэрийн үндэслэл нь рациональ шалгуурууд байгаа болно.

Олон зуун жилийн туршид “зөв эрх зүй”, “шударга ёс” гэдэгт ямар нэг объектив зүйлийг ойлгож байсан ба тодруулж хэлбэл, танин мэдэхүйн

²⁸ Kaufmann A., 1997. Rechtsphilosophie үзнэ үү.

ухамсарт субстанц хэлбэрээр өртөгдөж буй зүйлийг бид объект гэж ойлгож байсан. Өөрөөр хэлбэл, дээрхи ойлголтыг тодорхойлогч "субъект - объект" -ын схемийн дагуу танин мэдэхүйн хүрээнд объект, субъект хоёрыг хооронд нь хатуу зааглаж, ямарч субъектив зүйл танин мэдэхүйн үйл явцад нөлөөлөхгүй байв. Жам ёсны буюу Натур эрхийн онолынхон эрх зүйн хүрээнд үндсэн ойлголт болж, чухал байр суурь эзэлдэг объектыг "натур" – ын хүрээнд олж тогтоох явцад олон нэр томъёо хоорондоо хутгалдсан. Гэвч ийм маягийн substanzontogie нь зөвхөн натур эрхийн онолуудын хувьд бус, мөн эрх зүйн талаархи позитивист онолтой зайлшгүй холбогддог. Учир нь түүний хувьд эрх зүй гэдэг нь позитив хууль тогтоомжтой ижил зүйл бөгөөд энэ нь эрх зүйг хэрэглэж буй этгээдийн зүгээс халдашгүй байх объектив зүйл юм. Гэхдээ энэхүү substanzontogie (субстанцтологи хандлага) нь алдаатай болох нь тогтоогдсон юм. Эрх зүй гэдэг нь үргэлж нэг талаас "натур" – аас, нөгөө талаас зүгээр л нэг абстракт–ерөнхий хэлбэрээр томъёолон гаргасан "хууль тогтоомжоос" бий болдоггүй. Эдгээр нь тодорхой хэмжээгээр эрх зүйг бүтээх процессын явцад (хууль тогтоох ажиллагааны явцад) бодитой эрх зүйг бий болгоход хэрэглэгдэх "түүхий эд" нь болж өгдөг. Энэхүү үзэл санаа бол шинэ зүйл биш юм. Аливаа нэг текстэд тайлбар хийх шинжлэх ухааны процесс буюу Фридрих Эрнст Даниел Шлайермахерын үеэс энэхүү үзэл санааны учир шалтгаан нь тодорхой болсон юм. Шлайермахерын үзлээр бол утга бүхий зүйлд чиглэгддэг оюунлаг шинжлэх ухааны (духовная наука) хувьд байгалийн шинжлэх ухаанаас ялгаатай нь "субъект-объект"-ын схем үйлчилж болохгүй явдал болно. Хэн нэгэн этгээд ямар нэгэн зүйлийн утгыг танин мэдэхийн тулд түүний талаархи "урьдчилсан (өмнөх ойлголт)" болон юуны өмнө тухайн этгээдийн тухайн зүйлийн талаархи "өөрийнх нь ойлголт" маш чухал юм. (танин мэдэхүйн процесс дахь) Дээрхи "ойлголт" гэдэг нь материаллаг зүйл биш (утга учир бол субстанц биш) ба мөн субъектив зүйл ч биш (рефлексив тухайн ситуацид чиглэгдсэн шинжтэй), харин илүү субъектив – объектив шинжийг нэгэн зэрэг агуулсан байна. Оюунлаг шинжлэх ухаанд рациональ мөн чанарыг хувийн мөн чанараас салангид авч үзэхийг оролдсон бүх оролдлогууд үгүйсгэгдсэн юм.

Иймд эрх зүй гэдэг нь бүрэлдэхүүн (зүйл, анги) бус, мөн нөхцөл байдал (натур) бус, харин акт учраас ямар нэг субъектээс хараат бус объект биш байна. Иймээс аливаа шийдвэр хуульд нийцэж буй эсэхийг тогтоох

процессыг үл тооцвол “объектив үнэнд нийцсэн эрх зүй” гэж байж таарахгүй юм. Эрх зүй нь Никлас Луманны (Niklas Luhmann) үзсэнээр зөвхөн “процессоор дамжин” хэрэгжих бололцоотой юу? Эсвэл эрх зүй бодитой байх нь “бодит зүйлд суурилагдсан (субстанцлаг гэсэн ойлголт биш) процесс”-оор дамжин биелэлээ олох уу? гэсэн асуултанд хүргэж байна. Ийнхүү “шударга ёсны процедурын онол”-ын үүднээс “зөв эрх зүй” нь эрх зүйн шийдэл гаргах процессын бүтээгдэхүүн гэж үзэж байна.

Орчин үеийн эрх зүйн онолын сэтгэлгээний бас нэг гол онол нь “Үнэний онол” мөн.

Үнэний онолууд болох konsensus, korrespondenz-ын онолууд нь туршлага, агуулгын шаардлагагүй хэмээн үздэг нь эрдэмтэдийн шүүмжлэлд нилээн өртөж байна. Учир нь үнэн гэж бодох нь цэвэр өөрийн харилцаа болж хувирснаар хэлбэрийн хувьд зөв мөртлөө худал хэллэг (бүх мэдүүлгүүд тохирох гэх мэт) үнэн болж хуульчлагдах бололцоотой юм. Өөрөөр хэлбэл зөвшилцлийн (konsensus) үнэний үндэс нь konsens бус, харин жинхэнэ шалгуур нь нэгдэл буюу konvergenz байх ёстой юм. Иймд хэллэгийн үнэн буюу зөвийн гол шалгуур нь konsens байх явдал биш, харин бие биенээсээ тусдаа хэд хэдэн субъектүүд нэгэн зүйлийн талаар бодитоор нэгдмэл нэгэн ойлголтонд хүрсэн нөхцөл байдал юм. Иймд konsensus, korrespondenz-ын онолуудын хэт нэг талыг баримталсаныг хооронд нь холбож нэгтгэсэн konvergenz-ын онол гэж бий болов. Үүнийг үнэний нэгдлийн онол хэмээн нэрлэж болно. Нэгдэл гэдэг нь субъектив үзэл бодлын зүгээр нэг бөөгнөрөл биш, харин гол үзэл санаа буюу хоорондоо холбоогүй янз бүрийн субъектүүдийн танин мэдэхүйн ойлголтуудыг нэгтгэсэн зүйл юм. Энэ утгаараа нэгдэл нь тодорхой зүйлийг танин мэдэх арга зүй төдийгүй үнэний шалгуур болж байна.

Ийнхүү орчин үед эрх зүйн философийн хандлага улам гүнзгийрэн хөгжиж байгаа боловч манай орны хувьд эрх зүйн философи нь танин мэдэхүй төдий байна. Доктор Н.Лүндэндоржийн хэлсэнчлэн²⁹ “эрх зүйн философийг мэдлэгийн тогтолцоо болголгүй эрх зүйн үзэгдэл, харилцааг задлан шинжилдэг сэтгэлгээний урлаг болгон” хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

²⁹ Н.Лүндэндорж. Хууль зүйн шинжлэх ухааны хэл нь философи /Монгол улсын эрх зүйн шинэтгэлд хууль зүйн шинжлэх ухааны үүргийг дээшлүүлэх зарим асуудал/ Өдрийн сонин.№-289, 2004.11.23

Резюме

В данной статье автор в рамках темы "Современные тенденции философии права" рассматривает тенденции развития современных теорий философии права и наряду с этим делает попытку определить их теоретико-методологические принципы.

А также изучив основные направления развития философии права не как к системе знаний, как сказано в трудах доктора Н.Лундэндорж, а считает, что философию права необходимо развить как искусства идеологии, анализирующее правовые явления и отношения.